

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Од ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2025/113/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Дархан-Уул аймаг 2025 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр: Утас: 70378845 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn</p> <p>Аудитор: Э.Эрдэнэбат Утас: 99352099 Цахим хаяг: tsesb.audit@gmail.com</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Асуудлыг онцолсон хэсэг	3
Аудитын гол асуудал	4
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	18
4.1 Ерөнхий зүйл	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.5.1 Завсрын аудитын талаар	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
5.1 Төлбөрийн акт	19
5.2 Албан шаардлага	20
5.3 Зөвлөмж	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1,14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ОД
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Х.БАЯРБИЛЭГ ТАНАА

Бодс. од. РТ № 119

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Од сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайланд онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 205,200.0 мянган төгрөгийн сурагч сандал, Орон нутгийн хөгжлийн сангаас 13,666.0 мянган төгрөгийн хөрөнгийг хүлээн авч, данс бүртгэлд бүртгэсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг нэмэгдүүлснээр цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардал 5,783,617.6 мянган төгрөг болж, өнгөрсөн оны гүйцэтгэлээс 38.6 хувиар өссөн байна.

Бусад асуудал

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Дархан Уул аймгийн Од сургуулийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 чиглэлээр 13 зорилтын хүрээнд 70 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 97.3 хувиар тайлагнасан байна. Мөн улирал бүр Боловсролын газарт ажлын тайланг хүргүүлж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,132,023,287.78	877,745,589.23
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	834,888,095.17	498,559,861.62
312	Банканд байгаа бэлэн мөнгө		
3121	төгрөг		
31211	Төрийн сангийн харилцах	834,888,095.17	498,559,861.62
33	АВЛАГА	-	-
332	Төлбөртэй үйлчилгээний авлага		
3351	Байгууллагаас авах авлага		
35	БАРАА МАТЕРИАЛ	297,135,192.61	379,185,727.61
351	Түүхий эд материал	-	-
3511	Тусгай зориулалттай материал		
3513	Эм боох материал		
354	Хангамжийн материал	297,135,192.61	379,185,727.61
35410	Бичиг хэргийн материал		
35420	Аж ахуйн материал		
35430	Сэлбэг хэрэгсэл		
35440	Түлш, шатах тослох материал		
3545	Барилгын засварын материал		
3546	Хүнсний материал	1,004,500.00	
35470	Бусад хангамжийн материал	296,130,692.61	379,185,727.61
36	НӨӨЦ БАРАА		
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	7,285,340,932.88	7,358,319,046.78
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ		
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7,285,340,932.88	7,358,319,046.78
392	Биет хөрөнгө	5,555,592,932.92	5,629,671,046.86
39201	Барилга, байгууламж орон сууц	5,452,224,312.35	5,423,402,064.35
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,100,951,463.41)	(1,318,642,929.53)
39203	Авто тээврийн хэрэгсэл		
39204	Хуримтлагдсан элэгдэл		
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,116,482,182.80	1,270,919,595.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	(282,961,710.79)	(449,251,225.47)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	350,848,495.65	674,124,354.65
39208	Хуримтлагдсан элэгдэл	(162,992,672.39)	(156,968,492.42)
39214	Бусад үндсэн хөрөнгө	17,962,582.00	17,962,582.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-	(3,592,516.44)
39217	Ном	164,981,206.71	171,717,613.92
393	Биет бус хөрөнгө	1,729,747,999.96	1,728,647,999.92
39301	Программ хангамж	6,624,300.00	6,624,300.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,224,300.04)	(3,324,300.08)
39303	Бусад биет бус хөрөнгө	1,725,348,000.00	1,725,348,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	8,417,364,220.66	8,236,064,636.01
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	-	-
51	Засгийн газрын хувь оролцоо		
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	4,327,139,557.83	4,327,139,557.83
51101	Өмч: - төрийн		
512	Хуримтлагдсан үр дүн		(100,287,137.11)
51210	Өмнөх үеийн үр дүн	81,012,447.54	81,012,447.54
51220	Тайлант үеийн үр дүн		(181,299,584.65)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,009,212,215.29	4,009,212,215.29
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	8,417,364,220.66	8,236,064,636.01

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	7,189,496,954.82	8,385,744,212.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	859,337,654.82	840,106,112.00
120	Нийтлэг татварын бус орлого	859,337,654.82	840,106,112.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	859,337,654.82	840,106,112.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	62,065,200.00	115,920,300.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	24,980,448.00	46,650,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	552,645,896.76	416,406,438.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	219,646,110.06	261,129,374.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,330,159,300.00	7,545,638,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	6,172,496,100.00	7,356,135,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	6,172,496,100.00	7,356,135,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	157,663,200.00	189,502,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /Орон нутгийн төсөвт байгууллага/	157,663,200.00	189,502,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	6,284,637,148.80	8,501,799,948.86
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,284,637,148.80	8,501,799,948.86
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,707,237,094.80	7,858,874,338.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,171,226,002.00	5,783,617,651.00
210101	Үндсэн цалин	2,847,752,773.00	3,762,877,749.00
210102	Нэмэгдэл	1,142,123,848.00	1,688,344,717.00
210104	Урамшуулал	181,349,381.00	332,395,185.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	527,962,697.00	722,968,193.00
210201	Тэтгэврийн даатгал	358,967,765.84	491,446,150.00
210202	Тэтгэмжийн даатгал	40,956,618.02	58,035,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	34,856,118.78	29,017,850.00
210204	Ажилгүйдлийн даатгал	8,597,446.91	29,017,850.00
210205	Эрүүл мэндийн даатгал	84,584,747.45	115,450,643.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	148,608,457.00	158,192,514.59
210301	Гэрэл, цахилгаан	32,212,124.58	36,313,224.50
210302	Түлш, халаалт	81,146,573.55	84,339,452.60
210303	Цэвэр, бохир ус	35,249,758.87	37,539,837.49
210304	байрны түрээс		




2104	Хангамж, бараа материалын зардал	1,011,600.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,011,600.00	
2105	Нормативт зардал	1,938,450.00	-
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,938,450.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	195,333,060.00	275,027,183.00
210601	Багаж, техник хэрэгсэл	2,690,200.00	-
210604	Урсгал засвар	192,642,860.00	275,027,183.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	63,035,294.70	92,679,656.11
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,765,200.00	4,959,400.00
210806	мэдээлэл, технологийн үйлчилгээ	41,270,094.70	87,720,256.11
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	598,121,534.10	826,389,140.75
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	139,033,609.13	236,854,436.44
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	60,406,759.49	56,750,115.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	398,681,165.48	532,784,589.31
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	577,400,054.00	642,925,610.41
2132	Бусад урсгал шилжүүлэг	577,400,054.00	642,615,525.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	469,546,554.00	505,257,525.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	107,853,500.00	137,358,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	310,085.41
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		310,085.41
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	904,859,806.02	(116,055,736.86)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		65,243,847.79
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		22,987,228.00
225010			42,256,619.79
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН		(65,243,847.79)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	904,859,806.02	(181,299,584.65)




2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	6,417,204,948.00	7,708,208,400.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	87,045,648.00	162,570,300.00
120	Нийтлэг татварын бус орлого	87,045,648.00	162,570,300.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	87,045,648.00	162,570,300.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	62,065,200.00	115,920,300.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	24,980,448.00	46,650,000.00
13	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,330,159,300.00	7,545,638,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	6,172,496,100.00	7,356,135,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	6,172,496,100.00	7,356,135,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	157,663,200.00	189,502,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	157,663,200.00	189,502,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,720,350,031.83	7,789,936,520.55
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,720,350,031.83	7,789,936,520.55
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,141,945,477.83	7,148,015,410.14
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	4,171,226,002.00	5,783,617,651.00
210101	Үндсэн цалин	2,847,752,773.00	3,762,877,749.00
210102	Нэмэгдэл	1,142,123,848.00	1,688,344,717.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	181,349,381.00	332,395,185.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	-
2102	Ажил олгогчийн нийгмийн даатгалд төлөх шимтгэл	527,962,697.00	722,968,193.00
210201	Тэтгэврийн даатгалын	358,967,765.84	491,446,150.00
210202	Тэтгэмжийн даатгалын	40,956,618.02	58,035,700.00
210203	ҮОМШӨ-ий даатгалын	34,856,118.78	29,017,850.00
210204	Ажилгүйдлийн даатгалын	8,597,446.91	29,017,850.00
210205	Эрүүл мэндийн даатгалын	84,584,747.45	115,450,643.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	148,608,457.00	158,192,514.59
210301	Гэрэл, цахилгаан	32,212,124.58	36,313,224.50
210302	Түлш, халаалт	81,146,573.55	84,339,452.60
210303	Цэвэр, бохир ус	35,249,758.87	37,539,837.49
2106	Эд хогшил урсгал засвар	20,974,670.00	41,629,000.00
210601	Багаж техник хэрэгсэл	141,000.00	629,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		
210604	Урсгал засвар	20,833,670.00	41,000,000.00
2107	Томиллолт, зочны зардал		



210702	Дотоодын томилолт		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын, үйлчилгээний төлбөр, хураамж	63,247,294.70	95,880,656.11
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,765,200.00	4,959,400.00
210806	мэдээлэл, технологийн үйлчилгээ	41,482,094.70	90,921,256.11
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	209,926,357.13	345,727,395.44
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	150,404,559.13	267,635,480.44
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	59,521,798.00	78,091,915.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	578,404,554.00	641,921,110.41
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	-
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	578,404,554.00	641,611,025.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	470,551,054.00	504,253,025.00
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	107,853,500.00	137,358,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	310,085.41
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		310,085.41
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	-
3	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	696,854,916.17	(81,728,120.55)
4	Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогын дүн		
5	Хөрөнгө оруулалтын мөнгөн зардлын дүн	226,703,623.00	254,600,113.00
	Дотоод эх үүсвэр	226,703,623.00	254,600,113.00
222001	Тоног төхөөрөмж	169,307,000.00	152,459,900.00
223001	Бусад хөрөнгө	57,396,623.00	102,140,213.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	226,703,623.00	254,600,113.00
6	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(226,703,623.00)	(254,600,113.00)
8	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	470,151,293.17	(336,328,233.55)
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		834,888,095.17
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		498,559,861.62



2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
S01	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	4,327,139,557.83	4,009,212,215.29	(823,847,358.48)	-	7,512,504,414.64
S02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
S03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,327,139,557.83	4,009,212,215.29	(823,847,358.48)	-	7,512,504,414.64
S04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					-
S05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					-
S06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
S07	Тайлант үеийн үр дүн			904,859,806.02		904,859,806.02
S08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,327,139,557.83	4,009,212,215.29	81,012,447.54	-	8,417,364,220.66
D01	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
D02	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,327,139,557.83	4,009,212,215.29	81,012,447.54	-	8,417,364,220.66
D03	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					-
D04	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					-
D05	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
D06	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					-
D07	Тайлант үеийн үр дүн			(181,299,584.65)		(181,299,584.65)
D08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,327,139,557.83	4,009,212,215.29	(100,287,137.11)	-	8,236,064,636.01



2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	8,542,788,200.00	8,044,226,548.14	(498,561,651.86)	94.17
21	Урсгал зардлын дүн	8,542,788,200.00	7,789,626,435.14	(753,161,764.86)	94.17
210	Бараа үйлчилгээний зардал	7,847,377,800.00	7,148,015,410.14	(699,362,389.86)	94.33
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,053,103,800.00	5,783,617,651.00	(269,486,149.00)	95.55
210101	Үндсэн цалин	4,194,201,000.00	3,762,877,749.00	(431,323,251.00)	89.72
210102	Нэмэгдэл	1,541,269,100.00	1,688,344,717.00	147,075,617.00	109.54
210103	Унаа хоолны хөнгөлөлт			-	
210104	Урамшуулал	317,633,700.00	332,395,185.00	14,761,485.00	104.65
210105	Гэрээт ажлын хөлс	-	-	-	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	756,638,000.00	722,968,193.00	(33,669,807.00)	95.55
210201	Тэтгэврийн даатгал	514,513,800.00	491,446,150.00	(23,067,650.00)	95.52
210202	Тэтгэмжийн даатгал	60,531,100.00	58,035,700.00	(2,495,400.00)	95.88
210203	ҮОМШӨ-ний даатгал	30,265,500.00	29,017,850.00	(1,247,650.00)	95.88
210204	Ажилгүйдлийн даатгал	30,265,500.00	29,017,850.00	(1,247,650.00)	95.88
210205	ЭМД-ын хураамж	121,062,100.00	115,450,643.00	(5,611,457.00)	95.36
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	158,194,700.00	158,192,514.59	(2,185.41)	100.00
210301	Гэрэл, цахилгаан	36,158,000.00	36,313,224.50	155,224.50	100.43
210302	Түлш, халаалт	89,708,000.00	84,339,452.60	(5,368,547.40)	94.02
210303	Цэвэр, бохир ус	32,328,700.00	37,539,837.49	5,211,137.49	116.12
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	113,710,900.00	41,629,000.00	(72,081,900.00)	100.00
210601	Багаж хэрэгсэл	9,000,000.00	629,000.00	(8,371,000.00)	100.00
210602	Тавилга	63,710,900.00	-	(63,710,900.00)	100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл			-	100.00
210604	Урсгал засвар	41,000,000.00	41,000,000.00	-	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	183,210,400.00	95,880,656.11	(87,329,743.89)	52.33
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,959,400.00	4,959,400.00	-	100.00
210806	мэдээлэл, технологийн үйлчилгээ	178,251,000.00	90,921,256.11	(87,329,743.89)	51.01
210807	Газрын төлбөр				



2109	Бараа үйлчилгээний бусад зардал	582,520,000.00	345,727,395.44	(236,792,604.56)	90.68
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	499,222,700.00	267,635,480.44	(231,587,219.56)	89.13
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	83,297,300.00	78,091,915.00	(5,205,385.00)	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	695,410,400.00	641,611,025.00	(53,799,375.00)	92.31
2132	Бусад урсгал шилжүүлэг	695,410,400.00	641,611,025.00	(53,799,375.00)	92.26
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	558,052,400.00	504,253,025.00	53,799,375.00	90.36
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	137,358,000.00	137,358,000.00	-	100.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	254,600,113.00		
	Дотоод эх үүсвэрээр		254,600,113.00		
	Тоног төхөөрөмж		152,459,900.00		
	Бусад хөрөнгө		102,140,213.00		
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	8,542,788,200.00	7,707,898,314.59		100.00
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	7,356,135,500.00	7,356,135,500.00	-	100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	7,356,135,500.00	7,356,135,500.00	-	100.00
	Өмнөх оны үлдэгдэл	834,579,800.00			
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	189,502,600.00	189,192,514.59		
132001	Орон нутгийн төсвөөс	189,502,600.00	189,192,514.59	310,085.41	100.00
120004	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	162,570,300.00	162,570,300.00	0.00	100.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	115,920,300.00	115,920,300.00	-	100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	46,650,000.00	46,650,000.00	-	100.00
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	834,888,095.17	834,888,095.17	-	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		498,559,861.62	(498,559,861.62)	
1	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.00
3	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.00
	АЖИЛЛАГСАДЫН ТОО	237.00	216.00	21.00	91.14
	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
	Гүйцэтгэх ажилтан	196.00	176.00	20.00	100.00
	Үйлчлэх ажилтан	40.00	38.00	2.00	95.00
	Гэрээт		1.00	(1.00)	
	Төрийн өмчит ЕБС	4104	4104		100



3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан-уул аймгийн Дархан сумын Од ерөнхий боловсролын сургууль нь сургуульд суурилсан менежментийн хүрээнд 4 хөтөлбөр боловсруулан эрхэм зорилгоо :

- Суралцах чадвараа хөгжүүлсэн хүүхэд
- Хүндэтгэлтэй харилцаатай хүүхэд
- Эрүүл чийрэг биетэй хүүхэд төлөвшүүлнэ гэж тодорхойлон эрхэм зорилгын хүрээнд :

Тэргүүлэх 4 зорилт -ыг дэвшүүлсэн байна.

- Суралцах суурь чадвар
- Сурах арга барил
- Хувийн соёл төлөвшил
- Манлайлал оролцоо

Тэргүүлэх 4 зорилтын үйл ажиллагааны чиглэл:

- Уншигч-од
- Суралцагч-од
- Хамтач –од
- Манлайлагч-од 4 хөтөлбөр боловсруулан үйл ажиллагааныхаа үндсэн чиг үүрэгтэй уялдуулан хичээл сургалтын үйл ажиллагаагаа явуулж байна.

Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус газар нь Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын “Аргачлал, зардлын норматив батлах тухай” 2022 оны А/23,27 дугаар тушаал зэргийг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль зэрэг үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомжуудад нэмэлт өөрчлөлтүүд орсон байна.

Төсвийн шууд захирагч зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан Уул аймгийн Дархан сумын Од ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг газрын даргын 2021 оны А/02 дугаар тушаалаар баталж, мөн оны 01 дүгээр сараас мөрдөж эхэлсэн бөгөөд өөрчлөлт ороогүй, нягтлан бодох бүртгэлийн стандарт, санхүүгийн программтай нийцсэн байна. Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх НББ-ийн журам”-ыг үндэслэн 2025 оноос Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулж мөрдөж ажиллана.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дархан Уул аймгийн Дархан сумын Од ерөнхий боловсролын сургууль нь 2024 оны санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйл, УСНББОУС -ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нэмэлт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 181,299.6 мянган төгрөгөөр буюу 2.2 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

			/мянган төгрөгөөр/
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	834,888.10	498,559.90	(336,328.20)
Бараа материал	297,135.20	379,185.70	82,050.50
Үндсэн хөрөнгө	7,285,340.90	7,358,319.00	72,978.10
Нийт хөрөнгө	8,417,364.20	8,236,064.60	(181,299.60)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	4,327,139.60	4,327,139.60	-
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,009,212.20	4,009,212.20	-
Хуримтлагдсан үр дүн	81,012.40	(100,287.20)	(181,299.60)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	8,417,364.20	8,236,064.60	(181,299.60)

Тайлант онд төрийн сангийн харилцах дансанд үлдэгдэл 181,299.6 мянган төгрөг байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 379,185.7 мянган төгрөг болж 82,050.5 мянган төгрөгөөр өссөн нь Боловсрол Шинжлэх Ухааны Яамны хөрөнгө оруулалтаар ирсэн 21,316.1 мянган төгрөгийн ном сурах бичиг, Дархан-Уул аймгийн Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 221,654.5 мянган төгрөгийн спорт залны их засвар, Дархан сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 7,046.0 мянган төгрөгийн сэтгэл зүйчийн өрөөний урсгал засвар, хандив тусламжаар ирсэн 11,112.6 мянган төгрөгийн барилгын засварын материал нийт 261,129.4 мянган төгрөгийн бараа материалыг Од сургуулийн захирлын 2024 оны 9 дүгээр сарын 30-ны А/44 тоот тушаал,

2024 оны 10 дугаар сарын 30-ны А/50 тоот тушаал, Дархан-Уул аймгийн Засаг Даргын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 01-А/524 захирамж, захирлын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/61 тоот тушаалуудыг тус тус үндэслэн үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал дансанд бүртгэж, урсгал төсвийн санхүүжилтээр 804,821.1 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 983,900.0 мянган төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 7,358,319.0 мянган төгрөг болж 72,978.1 мянган төгрөгөөр өссөн нь Боловсролын Яам, Боловсролын Ерөнхий Газраас шилжүүлэн авсан 80,049.5 мянган төгрөгийн ном, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, Дархан сумын орон нутгийн хөгжлийн сан, Боловсрол-2032 хөтөлбөрийн хүрээнд Дархан-Уул аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар тус тус ирсэн 250,160.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг хүлээн авч, Орон нутгийн өмчийн газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн А/16 тоот албан бичгийг үндэслэн 120,142.7 мянган төгрөгийн үлдэх өртөггүй хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоож, дахин үнэлгээгээр 86,196.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг тус тус бүртгэж, Од сургуулийн захирлын 2024 оны 9-р сарын 30-ны А/44 тоот, 2024 оны 10 дугаар сарын 30-ны А/50 тоот, 2024 оны 11 дүгээр сарын 25-ны А/54 тоот, 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/61 тоот тушаалууд, Дархан-Уул аймгийн Засаг Даргын 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 01-А/517 захирамж Дархан-Уул аймгийн Засаг Даргын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 01-А/524 тоот захирамж, Дархан-Уул аймгийн ИТХ-н 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн тогтоолыг тус тус үндэслэн үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө дансанд бүртгэж, Дархан-Уул аймгийн Засаг Даргын 2024 оны 7 дугаар сарын 3-ны 01-А/313 тоот захирамжаар, захирлын 2024 оны 7-р сарын 8-ны өдрийн А/34 тоот тушаалаар, Дархан-Уул аймгийн ИТХ-н 2024 оны 7 дугаар сарын 31-ны 29 тоот тогтоолоор 95,236.4 төгрөгийн үндсэн хөрөнгө акталж, тайлант онд 532,784.6 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан зэргээс шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 8,236,064.6 мянган төгрөг болж 181,299.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн шууд захирагч 2024 оны төсвийн төсөлд орон нутгийн төсвийн нийт зарлагыг 245,867.8 мянган төгрөгөөр, улсын төсвийн төсөлд нийт зарлагыг 7,254,335.7 мянган төгрөгөөр тооцож, санхүүжих эх үүсвэрийг улсын төсөв, орон нутгийн төсөв, өөрийн орлогоос бүрдүүлэхээр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлжээ.

Дээд шатны төсвийн захирагч орон нутгийн төсвийн санал 245,867.8 мянган төгрөгийг 56,365.2 мянган төгрөгөөр бууруулж, 189, 502.6 мянган төгрөгөөр баталсан бол улсын төсвийн санал 7,254,335.7 мянган төгрөгийг зардлын зүйл ангилал нэмэгдсэн, хувьсах зардлын итгэлцүүр өөрчлөгдсөнтэй холбоотойгоор 110,355.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн анх 7,364,691.6 мянган төгрөгөөр баталсан.

Тайлант онд батлагдсан улсын төсвийг 2024.03.28-ны Төрийн албан хаагчийн зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох Засгийн газрын 128 дугаар тогтоол цалин хөлсний бүтцэд орсон өөрчлөлт, Боловсрол Шинжлэх Ухааны Сайдын А/170 дугаар тушаалын хэрэгжилтээр байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ,

багшийн гүйцэтгэлийн үнэлгээ, нөхөн хангалтын зардлууд, өөрийн үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогын өсөлт, урьд оны үлдэгдэл нийт 978,901.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 14 арга хэмжээг санхүүжүүлэхдээ улсын төсвөөс 7,356,135.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 189,502.6 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс санхүүжих 834,579.8 мянган төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлого 162,570.3 мянган төгрөг нийт 8,542,788.3 мянган төгрөг бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 189,502.6 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос 189,192.5 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдсэн 310,1 мянган төгрөгийг төвлөрүүлж, туслах үйл ажиллагааны 162,570.3 мянган төгрөгийн орлогын зарцуулж, улсын төсвөөс 7,356,135.5 мянган төгрөгийн санхүүжилт, өмнөх оны үлдэгдлээс 834,888.1 мянган төгрөгийг тус тус зарцуулж, 498,559.8 мянган төгрөг үлдсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 8,044,226.6 мянган төгрөг буюу 94.16 хувьтай байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд 489,559.9 мянган төгрөгийн зардлыг тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71802-Ерөнхий боловсрол				
1.1	80226-Байр ашиглалтын үйлчилгээ	20,824.40	20,824.40	-	100.00%
1.2	80233-Хүүхэд хамгаалал	17,467.20	17,467.20	-	100.00%
1.3	80312-Сургалт семинар	14,900.20	14,900.20	-	100.00%
1.4	81605-Эрүүл мэндийг дэмжих	20,824.40	12,716.00	(8,108.40)	61.06%
1.5	81801-Үдийн цай хөтөлбөр	558,052.40	504,253.03	(53,799.37)	90.36%
1.6	81816-Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	141,844.20	141,844.20	-	100.00%
1.7	81823- Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх	65,257.90	27,774.10	(37,483.80)	42.56%
1.8	81834- Боловсролын стандарт, сургалтын үйл ажиллагаа	6,747,878.60	6,381,614.88	(366,263.72)	94.57%
1.9	81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа	558,585.90	548,755.54	(9,830.36)	98.24%
1.1	81844- Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	135,610.90	135,610.90	-	100.00%

1.11	81848- Сурах бичгийн түрээс	4,959.40	4,959.40	-	100.00%
1.12	81875- Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх	45,388.00	22,314.19	(23,073.81)	49.16%
1.13	83603-Нэмэлт - Дээд шатны төсвөөс хуваарилсан	12,000.00	12,000.00	-	100.00%
1.14	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	199,194.70	199,192.56	(0.40)	100.00%
Нийт дүн		8,542,788.20	8,044,226.60	(498,559.86)	100.00%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Ахмад настны тухай хуулийн 14.7-д “Аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр “Ахмадын сан” байгуулах бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Тайлант онд тус цэцэрлэг нь удирдах 1 ажилтан, гүйцэтгэх 176 ажилтан, үйлчлэх 39 ажилтан буюу нийт 216 ажилтантайгаар ажиллаж, 210801- Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжын зардалд 95,880.7 мянган төгрөг, 210901- Бараа үйлчилгээний бусад зардалд 444,948.4 мянган төгрөгийг зарцуулж, худалдан авах ажиллагаатай холбоотой 933,058.4 мянган төгрөгийн ажил, үйлчилгээ төлөвлөж ажилласан байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд нэмэлт санхүүжилт аваагүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

2024 онд 22 төсөл арга хэмжээг 933,058.4 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулсан ба үдийн хоол хөтөлбөрийн хүнсний материал худалдан авах 507,470.4 мянган төгрөгийн нээлттэй тендер шалгаруулалт, 122,007.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авах цахим дэлгүүрийн ерөнхий гэрээний арга, 24,656.5 мянган төгрөгийн англи хэлний PEARSON хөтөлбөр хэрэгжүүлэгч сонгох Харьцуулалтын аргын тендерийг тус тус зохион байгуулж тендерийн болон ерөнхий гэрээ хийн гүйцэтгэлийг 100% хангуулан ажилласан.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дархан Уул аймгийн Од ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн ахмадын сантай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “ЦЭСБ-Аудит” ХХК-ийн аудитор Ч.Мөнхбаяр гүйцэтгэж анхан шатны хяналтыг чанарын менежер Т.Эрдэнэтуяа, захирал Ч.Цэрэннадмид, дараагийн шатны хяналтыг ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан-Уул аймгийн Од ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 29 тоот албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,963,141.9 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 29,631.40 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Дархан Уул аймгийн Од ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны төсвийг батлахдаа Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд хуулийг хэрэгжүүлж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 4 шалгуур үзүүлэлтээр шалгахад шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулбал зохих 171 мэдээллийг бүрэн байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д " Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д заасны дагуу "Ахмадын сан" байгуулж, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан "Ахмадын сан байгуулан ажиллах журам"-ын дагуу сангийн хөрөнгийг бүрдүүлж зарцуулан, гүйцэтгэлийг тайлагнаж, хяналт тавьж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус цэцэрлэгийн 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийхэд илрүүлсэн алдаа, зөрчил гараагүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар алдаа зөрчил илрээгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Боловсролын ерөнхий газрын 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр баталсан 7,254,335.7 мянган төгрөгийн төсвийн хуваарийг 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр 101,799.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдөр 284,603.9 мянган төгрөг төвлөрсөн тул харилцах дансны үлдэгдэл өсөж төсвийн гүйцэтгэл 94.17 хувьтай гарсан байна. Иймд төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудлыг дараагийн шатны аудитаар шалгаж, шийдэл гаргах нь зүйтэй байна

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 12,510.1 мянган төгрөгийн зөрчил¹ илэрсэн тул төсвийг хохиролгүй болгох 9,422.1 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт, 3,088.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлээ.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Илрүүлэлт: Багш, ажилтан албан хаагчид ур чадварын нэмэгдэл хөлс олгохдоо тухайн сард дутуу ажилласан байхад үндсэн цалингаас бодож 3,028.9 мянган төгрөгийг илүү олгосон байгаа нь Хөдөлмөрийн тухай тухай хуулийн 42.1.3 дахь заалтад "гүйцэтгэсэн ажил үүрэгтээ тохирсон цалин хөлс авах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

5.1.2 Илрүүлэлт: Байгууллагын бичиг хэрэг, няравт илүү цагийн нэмэгдэл хөлс олгохдоо тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрүүлэн нярав М.Гэрэлтуяад 544,8 мянган төгрөг, нягтлан бодогч Э.Солонгод 74,6 мянган төгрөг нийт 619,4 мянган төгрөгийн илүү олгосон нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”-ын 3 дахь заалтад “Илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс тооцох цаг нь 4.1-т зааснаас бусад тохиолдолд тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрэхгүй байна” гэж заасантай нийцэхгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

5.1.3 Илрүүлэлт: Тайлант онд үнэсэлгүйгээр ажлаас чөлөөсөн Шүүхийн шийдвэрийн дагуу багш Д.Энхтунгалагт 5,773.871 төгрөг олгож цалингийн зардалыг нэмэгдүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах Төрийн албаны тухай хуулийн 50.1 “Иргэнийг, эсхүл улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчийг төрийн албанд хууль бусаар томилсон, чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ”, Захиргааны ерөнхий хуулийн 103.1 дэх заалтад “Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ”, Иргэний хуулийн 498.5 дахь заалтад “Энэ хуулийн 498.1, 498.2, 498.4-т заасан этгээд өөрийн шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан бол гэм хорыг арилгасан байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулах эрхтэй” гэснийг, Төсвийн тухай хуулийн 6.3.1 дэх заалтад “төсвийн .. зарлага, .. өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнахгэж заасантай тус тус нийцээгүй байна.

5.2 Албан шаардлага

Тайлант онд байгууллагын 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар “өөрчлөлтгүй” дүгнэлт авсан шалтгаанаар Дархан-Уул аймгийн Боловсролын газрын даргын А/141 дүгээр тушаалыг баримтлан сургуулийн захирлын үндсэн цалинг 2 дахин нэмэгдүүлж, 3,088.0 мянган төгрөгийн урамшуулал авсан нь Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2 дахь хэсэгт заасантай нийцээгүй тул албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Аудитын явцад зөвлөмж өгөгдөөгүй байна.

Тайлангийн 4.4.2 дахь хэсэгт дурдсан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5²-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газарт 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

² Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Алдааны товч утга	/мянган төгрөгөөр/																			
	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			Зөвлөмж										
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруулаагүй	Тоо		Дүн									
-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/											
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтан	Тоо	Дүн
Багш, ажилтан албан хаагчид ур чадварын нэмэгдэл хөлс олгохдоо тухайн сард дутуу ажилласан байхад үндсэн цалингаас бодож 3,028.9 мянган төгрөгийг илүү олгосон	1	3,028.9	1	3,028.9								
Байгууллагын бичиг хэрэг, няравт илүү цагийн нэмэгдэл хөлс олгохдоо тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрүүлэн нярав М.Гэрэлтуяад 544,8 мянган төгрөг, нягтлан бодогч Э.Солонгод 74,6 мянган төгрөг нийт 619,4 мянган төгрөгийн илүү олгосон	1	619.4	1	619.4								
Тайлант онд үнэслүүгээр ажлаас чөлөөсөн Шүүхийн шийдвэрийн дагуу багш Д.Энхтунгалагт 5,773.871 төгрөг олгож цалингийн зардалыг нэмэгдүүлсэн байна.	1	5,773.8	1	5,773.8								

